



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Тайлан хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас 2019 оны тайлан хүлээн авах хуваарийг нэгдүгээр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хуваарийг хоёрдугаар, тайлангийн нэгтгэл хийх статистикч эмч нарын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2019 оны статистикийн тайланг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор батлагдсан хуваарийн дагуу хүлээн авч, нэгтгэн холбогдох газарт тайлагнахыг Статистик, мэдээллийн хэлтэс /Н.Долгормаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалаар заагдсан тайлан мэдээг батлагдсан хуваарийн дагуу үнэн, зөв гаргаж, хянаж, хүлээлгэн өгөхийг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн нийт эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, ерөнхий эмч, эрхлэгч нарт даалгасугай.

4. Тайлангийн нэгтгэлд ажиллах статистикч эмч нарын ажилд зохицуулалт хийж, ажиллах боломж, нөхцөлөөр хангах, тус газрын тодорхойлолтыг үндэслэн Хөдөлмөрийн хуулийн дагуу илүү цагийн хөлсийг олгохыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Тайлангийн жилд статистик мэдээ, мэдээлэлд хайхрамжгүй хандсан, үндсэн баримтгүй, худал, дутуу, буруу ташаа мэдээ өгсөн эмч, эмнэлгийн ажилтан, статистикч их, бага эмч нарт хариуцлага тооцох, идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ажилтныг урамшуулах ажлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны "Журам батлах тухай" А/13 тушаалын дагуу зохион байгуулахыг Статистик, мэдээллийн хэлтэс /Н.Долгормаа/-т даалгасугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Л.Зэндмаа/-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500369

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн
А/180 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ТӨРИЙН ӨМЧИТ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАНГ
ХҮЛЭЭН АВАХ ХУВААРЬ**

№	Тайлан	Эмнэлгийн нэр	Хугацаа	Хүлээн авах мэргэжилтэн
1	ЭМБ-ын хүчин чадал, хүний нөөцийн тайлан ЭМТ 401	ХУДЭМТ, НДЭМТ, БНДЭМТ, СХДЭМТ, БЗДЭМТ, СБДЭМТ, БГДЭМТ, ЧДЭМТ	2019.12.16	Төрийн өмчит ЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
		Багахангай ДЭМТ, ШЭНТ, НТТТ, Жаргалант ТЭМТ, Гачуурт ТЭМТ, Хонхор ТЭМТ, Туул ТЭМТ	2019.12.17	
		Нийслэлийн зооноз өвчин судлалын төв, Энэрэл, Наркологийн эмнэлэг, СХНЭ, ХУНЭ, БЗНЭ, СБНЭ	2019.12.18	
		СЗКЭ, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн мэргэжлийн өвчний эмнэлэг, Төмөр замын төв эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв	2019.12.19	
		ЭМЯ, НЭМГ, ЭМХТ, НЭМХ, АШУУИС, Ач, Этүгэн, Эм зүйн ШУ-ны их сургууль, Энэрэл АУДС, Шинэ анагаах ухаан дээд сургууль, МҮИС, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг, ШШГЕГ-ын харьяа Хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг	2019.12.20	
2	Аймаг, нийслэлийн ЭМБ-ын үйл ажиллагааны тайлан ЭМТ 201	ШШГЕГ-ын харьяа Хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Төмөр замын нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн мэргэжлийн өвчний эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв	2020.01.08	Төрийн өмчит ЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
		БГДЭМТ, ЧДЭМТ, НДЭМТ, БНДЭМТ	2020.01.09	
		ХУДЭМТ, СХДЭМТ, БЗДЭМТ, СБДЭМТ	2020.01.10	
		Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, БЗДНЭ, СХДНЭ, СБДНЭ, ХУДНЭ	2020.01.13	
		НТТТ, ШЭНТ, Энэрэл, Наркологи, СЗКЭ	2020.01.14	
3	ХБӨ-ний эрт илрүүлгийн	ХУДЭМТ, СХДЭМТ, БЗДЭМТ, СБДЭМТ, БГДЭМТ, ЧДЭМТ, НДЭМТ, БНДЭМТ,	2020.01.09-	

	тайлан ЭМТ 103	Туул, Жаргалант, Хонхор, Багахангай	2020.01.15	
4	Сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны тайлан ЭМТ 102	Туул, Жаргалант, Гачуурт, Хонхор, Багахангай	2020.01.15	Төрийн өмчит ЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
5	Өрхийн ЭМТ-ийн үйл ажиллагааны тайлан ЭМТ 101	ХУДЭМТ, СХДЭМТ, БЗДЭМТ, СБДЭМТ, БГДЭМТ, ЧДЭМТ, НДЭМТ, БНДЭМТ	2020.01.09-2020.01.10	
6	Эрүүл мэндийн мэдээллийн сангийн үзүүлэлт ЭМТ-401.7	Бүх эрүүл мэндийн байгууллага	2020.01.08-2020.01.15	
7	Хүн амын амбулатори, стационарын өвчлөлийн тайлан ЭМТ 502, 503	Хүн амын халдварт ба халдварт бус өвчлөл, төрөлт, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тайлан /Hinfo 3.0 програмд шивсэн бааз, бодуулсан тайлангийн хамт/	2020.01.08-2020.01.15	Эрүүл мэндийн бааз мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
8	Хүн амын нас баралтын тайлан ЭМТ 504	Хүн амын нас баралт тайлан / Hinfo 3.0 програмд шивсэн бааз, бодуулсан тайлангийн хамт/	2020.01.08-2020.01.15	

Жич: Тайланг ЭМС-ын 2013 оны 450 дугаар тушаалаар батлагдсан маягтаар авна.


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дугаар сарын 05 -ны өдрийн
А/180 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАХ ХУВААРЬ**

№	Тайлан	Эмнэлгийн нэр	Хугацаа	Хүлээн авах мэргэжилтэн
		Клиник эмнэлэг	2019.12.02-2019.12.06	
1	ЭМБ-ын хүчин чадал, хүний нөөцийн тайлан ЭМТ 401	Ортой эмнэлэг	2019.12.09-2019.12.13	ХХЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
		Сувилал	2019.12.16-2019.12.19	
		Эмийн сан	2019.12.20-2019.12.27	
2	Хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан ЭМТ 202	Ортой эмнэлэг	2020.01.02-2020.01.08	ХХЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
		Клиник эмнэлэг	2019.12.23-2019.12.31	
3	Сувиллын үйл ажиллагааны тайлан ЭМТ 203	Сувилал	2020.01.01-2020.01.03	
4	Эмийн сангийн тайлан ЭМТ 201.27	Эмийн сан	2019.12.23-2020.01.08	
5	БЗДХ/ДОХ-ын төв, кабинетийн үйл ажиллагааны тайлан ЭМТ 304	БЗДХ-ын эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клиник эмнэлэг	2019.12.23-2019.12.27	ХХЭМБ-ын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн
6	Аж ахуйн нэгжийн орлого зарлагын тайлан ААНБ 2	Клиник эмнэлэг, ортой эмнэлэг, сувилал, эмийн сан	2020.02.03-2020.02.25	
7	Шүдний кабинетийн тайлан	Шүдний эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клиник эмнэлэг	2019.12.23-2019.12.27	
8	Хүн амын амбулатори, стационарын өвчлөлийн тайлан ЭМТ 502, 503	Хүн амын халдварт өвчлөл, төрөлт, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тайлан / Hinfo 3.0 програмд шивсэн бааз, бодуулсан тайлангийн хамт /	2020.01.02-2020.01.08	Эрүүл мэндийн бааз мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
9	Хүн амын нас баралтын тайлан ЭМТ 504	Хүн амын нас баралт тайлан / Hinfo 3.0 програмд шивсэн бааз, бодуулсан тайлангийн хамт/	2020.01.02-2020.01.08	

Жич: Тайланг ЭМС-ын 2013 оны 450 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу цахимаар авна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дугаар сарын 25 өдрийн
11/10 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ ХИЙХ СТАТИСТИКЧ
ЭМЧ НАРЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Албан тушаал	Ажилтны нэр	Ажиллах хугацаа
1	Нийслэлийн шүд эрүү нүүрний төв	Статистикч эмч	Л.Оюунчимэг	2020.01.09- 2020.01.20 хүртэл
2	Өргөө амаржих газар	Статистикч эмч	Д.Сумъяа	2020.01.09- 2020.01.20 хүртэл
3	ХУДЭМТ	Статистикч эмч	Д.Шүрэнчимэг	2020.01.09- 2020.01.20 хүртэл